

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо 2022/03/20

Nº 22/04

Улаанбаатар

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Утас: 976-7013-9949; Факс: 976-70139948

info@flg.mn, www.flg.mn

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64.2 дахь заалт, 65.1, 65,4 дэх заалт, 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76.1.2, 76.1.3-р дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 03-р сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

- 1. "Фронтиер Лэнд Групп" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4-р сарын 30-ны 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, Пума Империал зочид буудлын хурлын бага танхимд хуралдах танхимаар хуралдуулсугай.
- 2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 4-р сарын 12-ны өдрөөр тогтоосугай
- 3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг тогтоолын Хавсралт 1-р баталсугай.
- 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2022 оны 3-р сарын 30-ны өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад хүргүүлсүгэй.
- 5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 2-р баталж, 2022 оны 3-р сарын 25 болон 2022 оны 4-р сарын 11-ний өдрүүдэд тус тус Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам-д заасны дагуу олон нийтэд зарласугай
- 6. Хурлын хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг тогтоолын Хавсралт 3-р, санал авах хуудасны агуулга, загварыг тогтоолын Хавсралт 4-р, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг тогтоолын Хавсралт 5-р тус тус баталсугай.
- 7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг 2022 оны 4-р сарын 30-ний өдрийн 10:00 цагаар тасалбар болгосугай.
- 8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2022 оны 5-р сарын 4-ны дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлсүгэй

- 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Э.Тэмүүлинг томилсугай.
- 10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: М.Батбаатар

Гишүүн: Ч.Гэрэлмаа

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах

бүрэлдхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Р.Сайдаброр

Гишүүн: У.Анар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Э.ТЭМҮҮЛИН

Фронтиер Лэнд Групп ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 22/04 тоот тогтоолын Хавсралт 1

## "Фронтиер Лэнд Групп" ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалт

- 1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- 2. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө батлах
- 3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- 4. ТУЗ-ийн 2022 оны төсөв батлах
- 5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
- 6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
- 7. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх /Морьт Импекс ХХК-тай хийсэн гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг батлах
- 8. Хөрөнгө оруулалтын гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг батлах
- 9. Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах
- 10. Бусад